



МОНГОЛ УЛС
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

46083 Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон, 201 тоот
Утас: (976)70533620, Факс: (976)70533604,
И-мэйл: info@omnogovi.gov.mn, Вэб сайт: www.omnogovi.gov.mn

2020.04.06 № 1-914
танай -ны № -т

Г ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗАРТ

Өмнөговь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг 2020 оны эхний улирлын байдлаар нэгтгэн хүргүүлж байна.

Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хавсаргав.

Хавсралт 5 хуудастай

ЗАСАГ ДАРГА

Н.НАРАНБААТАР



Data D:/zdtg2020 /A5 ZD.doc

466190733

НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД 2020 ОНЫ ЭХНИЙ
УЛИРЛЫН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ,
ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

ТТБ № 2337

2020 оны 04 сарын 06

Даланзадгад

№	Нутгийн захиргааны байгууллагын төрөл	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт		Хугацаа хэтрүүлсэн	Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн			
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	177	135	-	-	42	76.2
2	Агентлагууд	2127	1828	1	-	299	85.9
3	Сумд	1265	1121	8	2	144	88.6
Дүн		3569	3084	9	2	485	84.0

oOo

Хавсралт № 2

ТТБ №: 2337

НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД 2020 ОНЫ
ЭХНИЙ УЛИРЛЫН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

/хэлбэрээр/

2020 оны 04 сарын 06

Даланзадгад

№	Нутгийн захиргааны байгууллагын төрөл	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Үүнээс			
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	177	156	21	-	-
2	Агентлаг	2127	2062	65	-	-
3	Сумд	1265	1142	12	36	75
Дүн		3569	3360	98	36	75

oOo

НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД 2020 ОНЫ
ЭХНИЙ УЛИРЛЫН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ
/Агуулгаар/

2020 оны 04 сарын 06

Даланзадгад

№	Аймгийн нэр	Зонхилж байгаа асуудал /Нийт өргөдөл гомдолд эзлэх хувь/																		
1	Өмнөговь аймаг	<p>Нийт 3659 өргөдлөөс:</p> <table> <tbody> <tr><td>1.</td><td>Хүсэлт</td><td>3431</td><td>/97.9/</td></tr> <tr><td>2.</td><td>Санал</td><td>43</td><td>/1.17/</td></tr> <tr><td>3.</td><td>Талархал</td><td>14</td><td>/0.38/</td></tr> <tr><td>4.</td><td>Гомдол</td><td>17</td><td>/0.5/</td></tr> </tbody> </table> <p>1. Боловсрол, соёл, урлаг, спорт – 543 /14.8/ 2. Эрүүл мэнд, нийгмийн даатгал – 527 /14.4/ 3. Тусlamж, дэмжлэг хүсэх – 459 /12.5/ 4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр – 331 /9.04/ 5. ЗДТГ-ын бодлого, үйл ажиллагаа – 213 /5.8/ Иргэдээ сонсох 7053-0001 утсанд 2020 оны эхний улирлын байдлаар нийт 36 санал, хүсэлт, гомдол ирснээс гомдол 19, санал 1, хүсэлт 17 ирсэн байна. Эдгээрээс боловсролын салбартай холбоотой дуудлага мэдээлэл 7, эрүүл мэндийн салбарт 9, дулаан халаалттай холбоотой 3, хөл хороо тогтоосонтой холбоотой 17 мэдээлэл, дуудлага тус тус ирсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> Аймгийн хэмжээнд 2020 оныг “Өрх, гэр бүлийн хөгжлийн жил”, салбарын хувьд Боловсролыг дэмжих жил болгон зарласны хүрээнд агаарын бохирдлыг бууруулах, гэр хорооллын хөгжлийг дэмжих, ядуурлыг бууруулах, ард иргэдийнхээ амьжиргааны түвшин, амьдралын чанарыг нэмэгдүүлэх, сургалтын чанарыг сайжруулах асуудлыг цогцоор нь шийдэхээр төлөвлөөд байна. 	1.	Хүсэлт	3431	/97.9/	2.	Санал	43	/1.17/	3.	Талархал	14	/0.38/	4.	Гомдол	17	/0.5/		
1.	Хүсэлт	3431	/97.9/																	
2.	Санал	43	/1.17/																	
3.	Талархал	14	/0.38/																	
4.	Гомдол	17	/0.5/																	

oOo

ТАНИЛЦУУЛГА

/2020 оны эхний улирлын байдлаар иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, хүсэлт шийдвэрлэлтийн тухай/

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан цахимаар буюу /URGUDUL.OMNOGOVI.GOV.MN/-ээр дамжуулан ирүүлж буй өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч И-Оффис программаар дамжуулан тухайн иргэн, хуулийн этгээдэд хариу мэдээлэл өгөх үйл явцыг түргэтгэх зорилгоор нийт сум, агентлагийн өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтнүүдэд арга зүйн зөвлөмжийг цаг тухай бүрт нь өгч ажиллаж байна. Өргөдөл гомдол, санал хүсэлтийн цахим программын ашиглалтын хувь өмнөх оны мөн үеэс 7,5 дахин өссөн үзүүлэлттэй буюу тайлант оны эхний улирлын байдлаар 98 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд Олон улсын чанарын менежментийн ISO9001:2015 стандартыг нэвтрүүлж буйтай холбоотойгоор иргээдэд мэдээллийг ил тод нээлттэй болгох тал дээр анхаарч мэдээллийн самбаруудыг илүү ойлгомжтой, тодорхой болгон шинэчиллээ.

Цаашид анхаарах асуудал:

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний улирлын байдлаар иргэдээс 3659 өргөдөл, хүсэлт ирүүлснээс 2 буюу 0.05 хувийг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн байна. Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 2 өргөдөл нь газар эзэмших, ашиглахтай холбоотойгоор Ханбогд сумын Засаг даргын Тамгын газарт хаяглан шийдвэрлүүлэхээр ирүүлсэн. Иргэдээс ирүүлсэн өргөдлийг хүлээн авч бүртгэх үйл ажиллагааг гажуудуулсан, программ дээр бүртгэл хийдэггүй албан хаагчдыг хариуцлагажуулах, зөрчил гаргасан нь тогтоогдсон албан хаагчид сахилгын арга хэмжээ тооцож ажиллах үүрэг чиглэлийг аймгийн Засаг даргаас өгсөн бөгөөд холбогдох сум, байгууллагын удирдлагуудад албан бичгийг хүргүүллээ.

Дэлхий нийтэд цар тахлын хэмжээнд тооцогдож буй Covid19 вирусын дэгдэлтэй холбоотойгоор хөл хорио тогтоосон нь иргэдэд техник технологийн дэвшлийг ашиглаж хэвших, цахим үйлчилгээг сурталчлах боломжийг нээж өгсөн зерэг талтай байлаа. Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, тэдгээртэй холбоотой хууль, эрх зүйн актуудын талаар сум болон байгууллагын өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтнүүдэд онлайн сургалтыг зохион байгуулж 35 албан хаагчийг хамрууллаа.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 06

Даланзадгад

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

Өмнөговь аймгийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын 06 дугаар тэмдэглэлд:

“VI.4 2020 оны эхний улиралд иргэдээс нутгийн захиргааны байгууллага албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн нутгийн захиргааны байгууллага, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн Д.Ууганбаяр зөвлөлийн хурлын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг нутгийн захиргааны байгууллага, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэнд даалгав:

1. иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдол, шийдвэрлэлтийн 2020 оны эхний улирлын тайлан мэдээг үнэн зөв, тодорхой гаргаж хуульд заасан хугацаанд багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх;

2. хугацаа хоцруулан шийдвэрлэсэн 2 өргөдөл гомдлыг хариуцсан байгууллага, албан тушаалтантай холбогдон нэмэлт тайлбар тодруулга авах, цаашид ийм зөрчил гаргахгүй байх талаар анхааруулах;

3. өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээг сум, агентлагуудаас аваходаа нэгдсэн нэг маягтаар авч хэвших, өөрөөр хэлбэл ямар төрлийн өргөдөл хүсэлтийг нэгтгэн ирүүлж байх ёстой талаар тодорхой ойлголт өгөх ажлыг зохион байгуулах;

4. иргэдээс цахимаар ирүүлж буй өргөдөл, хүсэлтийг хүлээн авч бүртгэх ажлыг чанартай зохион байгуулах, өргөдөл гомдлын цахим программын ашиглалтийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулах.” гэжээ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

